Үргэлжилсээр…

“Бодлогын мэдээний” өмнөх дугаараас хойш даруй таван сар өнгөрчээ. Энэ хугацаанд гадна болон дотоодод үй олон үйл явдал өрнөж өнөөдрийг, маргаашийг тодорхойлох болсон байна.

Манайд УИХ-ын ээлжит сонгууль болдгоороо болов. Парламент, засгийн газрын бүрэлдэхүүн харьцангуй шинэчлэгдэж, цаашдын зорилго, зорилтоо тодорхойлон, ажилдаа уухайлан оров гэлтэй. Юу бүтэв, юу нь бүтсэнгүй вэ гэдгийг ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр, мөн нэг жилийн ойгоор нь олон түмэн дүгнэх биз.

Харин даяарт Коронавирус хэмээх “үзэгдэл” үргэлжилж улс хоорондын харилцаа, улс бүрийн дотоодыг хүндрүүлсээр байна.

Өнөөдөр 10 дугаар сарын 5. Дэлхийн хэмжээнд 35,387,775 хүн халдвар авснаар бүртгэгдэж, 26,609,676 нь эдгэрч, 1,04,1537 хүний амь тэнгэрт хальсан мэдээ байна. Манайд 313 дахь халдвартан “импортлогдсон” авч “дотоодын халдваргүй” хэвээр. Гэхдээ элдэв хориг, эмх замбараа суларсаар…

Өглөө босоод титэмтийн тухай мэдээ хайдаг дадлаасаа салах цаг мөдгүй бололтой.

Х.Б.

* * *

“If you don’t vote, you lose the right to complain.”

George Carlin

“Politics is the art of looking for trouble, finding it whether it exists or not, diagnosing it incorrectly, and applying the wrong remedy.”

Ernest Benn

“Loyalty to country ALWAYS. Loyalty to government, when it deserves it.”

Mark Twain

“An appeaser is one who feeds a crocodile, hoping it will eat him last.”

Winston S. Churchill

С.Баттулга
Доктор, профессор

МЭРГЭЖЛИЙН ХАМГИЙН ТОМ ХОЛБОО БАЙГУУЛАГДЛАА

Хүн төрөлхтөн Covid-19 цар тахалтай нүүр тулан тэмцэж буй цаг үед Монгол улсад нэгэн чухал үйл явдал тохиож байна. Энэ бол олон улсын харилцаа, гадаад бодлого, аюулгүй байдал, орон судлалын чиглэлээр ажилладаг судлаач, мэргэжилтэн, сонирхогчид болон судалгааны байгууллагыг үндэсний хэмжээнд нэгтгэсэн "Монголын олон улс судлалын Алтан аргамж холбоо" Төрийн бус байгууллага (МОСААХ) энэ 8 дугаар сард албан ёсоор гэрчилгээгээ авч байгуулагдсан явдал юм.

Энэхүү МОСААХ-ны гол зорилго бол олон улсын харилцаа, гадаад бодлого, аюулгүй байдал, орон судлалын чиглэлээр үндэсний хэмжээнд төлөөлөх, мэдлэгийн сүлжээ-нэтворк үүсгэх, мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх, бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал юм.

Энэхүү зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд мэргэжлийн чиглэлийн сүүлийн үеийн хандлага, чиглэлийн талаар судалгаа, сургалт, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, үндэсний болон бүс нутаг, олон улсын судалгааны төв, судлаачидтай хамтран ажиллахад туслалцаа үзүүлэх, хамтран бодлогын судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, монголын болон гадаадын судлаачдын хооронд судалгааны үр дүнг хуваалцах, мэдээлэл солилцох замаар үндэсний эрх ашгийг хөндсөн олон улсын харилцааны асуудлаар нэгдсэн ойлголцлыг бий болгоход туслалцаа үзүүлэх, судлаачид хамтран бүтээл туурвих, хэвлэн нийтлэхэд туслах, жил бүр үндэсний хэмжээнд "Оны шилдэг бүтээл"-ийг шалгаруулан урамшуулах зэрэг ажлыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж байна.

МОСААХ-г үүсгэн байгуулах ажлыг дээрх мэргэжлийн чиглэлийн үндэсний хэмжээний судалгааны байгууллагууд, хувь судлаач, эрдэмтэд, дипломатч хамтран санаачилсан бөгөөд холбооны анхны Ерөнхийлөгчөөр ОББЭЭС, Шинжлэх ухааны доктор Ц.Батбаяр, Дэд Ерөнхийлөгчөөр Монгол улсын Батлан хамгаалахын сайд асан, доктор Ц.Цолмон, Гүйцэтгэх захирлаар МУИС-ийн ОУХНУС-ийн захирал, доктор С.Баттулга нар сонгогдон ажиллаж байна.

МОСААХ нь олон улсын харилцаа, гадаад бодлого, аюулгүй байдал, орон судлалын чиглэлээр ажилладаг, судалгаа хийдэг, сонирхдог төр, олон нийтийн байгууллага, бие даасан судлаач, оюутан, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн үндэсний хэмжээний байгууллага юм. Үндэсний хэмжээний хамгийн том холбоо МОСААХ-ны гишүүн байж, Монгол улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг нугаршгүй сэтгэлээр хамгаалахын төлөө хамтдаа зүтгэхийг Та бүхэнд уриалж байна.

Х.Аюурзана
Элчин сайд асан, судлаач

ВАН И САЙДЫН АЙЛЧЛАЛЫН ТУХАЙД

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Н.Энхтайваны урилгаар БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И 2020 оны 9 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

Ван И сайдын энэ удаагийн айлчлал нь коронавирусийн хорио цээрийн үед буюу өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлд халдвар хамгааллын хатуу горимын дор тохиосноороо онцлог байлаа. Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай орны хувьд дээд, өндөр түвшний харилцан айлчлалыг манай хоёр улс тогтмол хэрэгжүүлж ирсэн боловч Ковид-19 цар тахлын улмаас төлөвлөж байсан олон арга хэмжээг хойшлуулж, цуцалсан байсан. Хятад улс цар тахлыг хяналтдаа авсан, манай улс дотооддоо алдаагүй байгаа нь өндөр түвшний айлчлал хэрэгжүүлэх боломжийг олгож байна гэж үзэж энэхүү айлчлалыг хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. Айлчлалыг манай улсад өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлд халдвар, хамгааллын горимыг хатуу сахиж, арга хэмжээнүүдэд нь аль болох цөөн хүн оролцуулахаар зохицуулалтыг хийжээ.

Гадаад хэргийн сайд Ван И-гийн энэхүү айлчлал нь 2020 оны хоёрдугаар сард цар тахал гарсны дараахан Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНХАУ-д хийсэн айлчлалын хариу айлчлал гэж үзэж болох бөгөөд цар тахал гарч эхэлснээс хойш Монгол Улсад ирсэн гадаадын томоохон төлөөлөгчдийн анхны айлчлал боллоо.

Хоёр улсын хооронд дээд, өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, хоёр талын бүх салбарын хамтын ажиллагааг урагшлуулах, Ковид-19-ийн тархалтаас урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг үргэлжлүүлэхийн зэрэгцээ худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг сэргээхэд гарч буй ахицыг бататгах нь энэхүү айлчлалын гол зорилго байсан гэж үзэж болох юм.

Айлчлалын хүрээнд Ван И Монгол Улсын Гадаад харилцааны сайд Н.Энхтайвантай албан ёсны хэлэлцээ хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Ерөнхий сайд У.Хүрэлсүх нарт тус тус бараалхав.

Гадаад харилцааны сайд нарын албан ёсны хэлэлцээний үеэр Монгол Улс, БНХАУ-ын хооронд тогтоосон Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг тэргүүлэх салбаруудад идэвхжүүлэн гүнзгийрүүлэх, хамтын ажиллагааны өмнө хүрсэн тохиролцоог урагшлуулах, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг үргэлжлүүлэхийн зэрэгцээ худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг сэргээх зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг хэлэлцэж, олон улс, бүс нутгийн хамтын ажиллагааны асуудлаар санал солилцож, олон асуудлаар тохиролцоонд хүрчээ.

Хоёр тал бие биенийхээ тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэж, нөгөө талын хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмыг тууштай баримталж ажиллах нь чухал болохыг онцлон тэмдэглэжээ. Олон улсын харилцааны энэхүү түгээмэл зарчмуудыг аль ч орон бусад орнуудтай харилцахдаа баримталж байдаг юм.

Ойрын хугацаанд хэрэгжүүлэх боломжтой дээд, өндөр түвшний харилцан айлчлал, хамтын ажиллагааны голлох механизмуудын уулзалтын талаар ярилцсан нь өнөөдрийг хүртэл алсын зайнаас харилцаж байсан хэлбэрийг халах алхам гэж үзэж байна. Энд юуны өмнө манай хоёр орны хамтын ажиллагаанд чухал үүрэгтэй засгийн газар хоорондын комисс, эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн

хамтын ажиллагааны комисс, хүмүүнлэгийн солилцооны механизм зэргийн үйл ажиллагааг цар тахлын үед хэрхэн сэргээх асуудлууд яригдсан гэж ойлгож байна.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг сэргээн идэвхжүүлэхэд гарч буй ахицыг бататгах, хоёр талын томоохон төслүүдийн хэрэгжилтийг түргэтгэхэд анхаарч ажиллахаар болжээ. Хоёр талын худалдааны эргэлтийг улам бүр нэмэгдүүлэх зорилгоор цаашид идэвхтэй хамтран ажиллах, энэ хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг тогтвортой өсгөх, хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон байна. Энэ нь эдийн засгийн хүндрэлтэй байдалд ороод байгаа манай улсын хувьд нэн чухал ач холбогдолтой юм.

Талууд соёл, боловсрол, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэхийг дэмжиж ажиллахаа илэрхийлжээ.

Сайд нар бүс нутаг, олон улсын хамтын ажиллагааны асуудлаар ярилцаж, Монгол, Хятад, Оросын гурван талын хамтын ажиллагаанд гарч буй бодит ахицыг улам бататгах чиглэлээр хүч чармайлт гарган ажиллахаа илэрхийлсэн байна.

Мөн "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ноот бичиг" солилцож, Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, Гадаад харилцааны яам хоорондын 2021-2022 оны хамтран ажиллах төлөвлөгөө, Монгол Улсаас БНХАУ-д гурил экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээрийн шаардлагын тухай Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын Протокол гэсэн баримт бичгүүдийг байгуулсан байна.

Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрээр Монгол Улсад 700 сая юанийн буцалтгүй тусламж олгох болжээ. Энэ нь 2017 онд манай улсад олгохоор амласан 2 тэрбум юаний буцалтгүй тусламжийн сүүлчийн хэсэг бөгөөд өнөөгийн ханшаар тооцвол 290 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж юм.

Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээр"-т нэмэлт, өөрчлөлт оруулснаар Замын-Үүд – Эрээн төмөр замын боомтоос гадна Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч гэсэн гурван төмөр замын боомт нээгдэж байгаа нь манай экспорт, дамжин өнгөрөх тээврийн хэмжээ нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлнэ гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгатай хийсэн уулзалтын үеэр талууд хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг улам баяжуулж, хоёр улсын худалдааны хэмжээг 10 тэрбум ам.долларт хүргэх, цаашид улам нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд идэвх, санаачилгатай ажиллах, ингэхдээ нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний худалдааг хөгжүүлэх боломжуудын талаар санал солилцсон. Хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбарт түлхүү хөгжүүлэх нөөц бололцоо хангалттай байгааг Ерөнхийлөгч Х.Баттулга онцолж, Монголын цэвэр хөрс, ус, агаарт боловсорсон "эко" хүнсийг экспортлох сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Мөн Ерөнхийлөгч Х.Баттулгын бэлэглэсэн 30 мянган толгой хонийг хятадын талд хүлээлгэн өгөх бэлтгэл ажил ид явагдаж байгааг Ван И-д уламжилсан байна.

Ерөнхий сайд У.Хүрэлсүх Гадаад хэргийн сайд Ван И-тэй уулзах үеэрээ Монгол Улс, БНХАУ-ын хоорондын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэх, улс төрийн итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, дээд, өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, бүхий л салбарын хамтын ажиллагааг урагшлуулах, эдийн засгийн томоохон төслүүдийг идэвхжүүлэхээр тохиролцсон байна. Мөн уулзалтын үеэр талууд Өвөр Монголд үүсээд байгаа нөхцөл байдал, монгол хэл бичигтэй холбоотой асуудлыг хөндөн ярилцаж, өөрсдийн байр суурийг илэрхийлжээ.

Энэхүү айлчлалын үеэр болсон яриа хэлэлцээнд Орос, Монгол, Хятадын гурван талт хамтын ажиллагааны асуудлууд нэг гол сэдэв байжээ. Ялангуяа манай улсын хувьд Монгол улсын нутгаар дайруулан тавих "Сибирийн хүч-2" хий дамжуулах хоолойн асуудал нэн чухал юм. Мөн Хятадын "нэг бүс, нэг зам" төслийг манай "Талын зам" төсөлтэй холбох, гурван улсын эдийн засгийн

коридорын төслүүдийг хэрэгжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцсэн нь манай орнуудын хамтын ажиллагаанд түлхэц өгсөн гэж үзэж болох байна.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын гишүүн улсуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалтаас ирсэн Ван И тус уулзалтаар хэлэлцсэн асуудал, мөн үр дүнгийн талаар мэдээлсэн байна. Манай улс ШХАБ-ын хүрээнд ажиглагч орны статусаа ахиулах эсэх асуудал өнгөрсөн хугацаанд идэвхтэй яригдаж байгаа. Монгол улс хамгийн анхны ажиглагч улс болоод одоо 16 жил болж байна. Ерөнхийлөгч Х.Баттулгын хувьд ШХАБ дахь байр суурьиа ахисан түвшинд аваачих цаг нь болсныг хэлж байсан удаатай. Монгол Улсын Засгийн газар ШХАБ-д жинхлэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн судалсаар байгааг албаны хүмүүс хэлж байгаа. Тал талаас нь сайн судлах нь мэдээж чухал, гэхдээ манай улсын хувьд ямар ашиг тустай, ач холбогдолтой вэ гэдэг нааштай талаас нь авч үзэх хэрэгтэй байгаа юм. ШХАБ-ын хүрээнд гишүүн орнуудын хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа идэвхтэй явагдаж байна. Хил дамнасан хар тамхи, хүний наймаа зэрэг зохион байгуулалттай гэмт хэргүүд хаалга цохиж байгаа энэ үед бүс нутгийн орнуудтай нягт хамтран ажиллах шаардлага манай улсад байна. ШХАБ-д гишүүн боллоо гэхэд энэ нь манай улсын гадаад бодлогын үндсэн зарчим, чиглэл, гуравдахь хөршийн орнуудын харилцаанд сөрөг нөлөө үзүүлнэ гэж хэт болгоомжлох нь асуудлыг шийдвэрлэхэд саад болж байна. Өнөөдөр олон улсын харилцаа 20 дугаар зууны үеийнхээс огт өөр болсон гэдгийг бодолцох хэрэгтэй юм.

Олон улсын харилцааны бэрхшээлтэй шинэ нөхцөл байдалд болсон энэхүү айлчлал нь “Ковид-19”-ээс болоод зогсонги байдалд



ороод байсан манай хоёр орны олон чиглэлийн харилцаа, хамтын ажиллагааг сэргээн хөгжүүлэхэд түлхэц болсон гэж үзэж байна. БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И манай улсад богино хугацаатай айлчилсан ч айлчлалын үр дүн, ач холбогдлыг талууд өндрөөр үнэлж байна.

Манай хоёр улс хөрш орнууд учраас онц ноцтой цар тахлын шинэ нөхцөл байдалд харилцан бие биенээ дэмжиж, хүмүүнлэгийн тусламж болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлж ирсэн билээ. Энэ удаа Ван И сайдын айлчлалын үеэр үзүүлсэн буцалтгүй тусламж нь хятадын ард түмнээс монголын ард түмэнд хандаж буй найрсаг, элэгсэг дотно сэтгэлийн илэрхийлэл гэж хүлээж авах хэрэгтэй юм.

Ван И сайд нутагтаа буцаж очоод хийсэн хэвлэлийн бага хурал дээр “Цар тахал урт хугацаанд үргэлжилж байгаа үед халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулахын зэрэгцээ хятадын тал шат дараатай, аюулгүй байдлыг хангаж гадаад харилцаагаа сэргээх асуудлыг чухалчлан анхаарч байна” гээд эрүүл торгоны зам байгуулахыг онцлон тэмдэглэсэн байна.

Дэлхийн улс орнууд бүхэлдээ шинэ нөхцөл байдалд дасан зохицож, сүүлийн саруудад гадаад айлчлал, арга хэмжээ, олон талт уулзалтууд идэвхжиж байна. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И 8 дугаар сарын 25-наас 9 дүгээр сарын 1-ний өдрүүдэд Европын зарим улсад айлчлал хийсэн бөгөөд Монгол Улсад айлчлахаасаа өмнө ОХУ-д болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын (ШХАБ) Гадаад хэргийн сайдын нарын зөвлөлийн хуралдаанд оролцож, дараа нь ОХУ, Казахстан, Киргиз Улсад айлчилсан юм.

К. Дэмбэрэл
ШУА-ийн ОУХХ-ийн ЭШАА, доктор (Ph.D)

ОХУ БА БНХАУ-ЫН ХАРИЛЦААНЫ ҮЕЧЛЭЛИЙН АСУУДАЛД (1991-2020)

Орос-Хятад, Орос-Япон, Орос-Энэтхэг, Орос-Төв Азийн гэсэн 4 чиглэлийг[1], ялангуяа ОХУ, БНХАУ-ын гадаад бодлого, тэдгээрийн үзэл баримтлал, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны мөн чанарыг байнга анхааралдаа авч, судалж байх нь Монгол улсын гадаад харилцаанд чухал. Орос-Хятадын харилцаа, хамтын ажиллагаа нь 1991-2020 онуудад хэрхэн хөгжиж ирсэн талаар тоймлонгоо ирэх 10 жилд буюу 2030 он хүртэлх хоёр хөршийн харилцааны талаар судлаачийн байр суурьиа илэрхийлье.

1 К.Дэмбэрэл. Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс. УБ., 2018. 270-р тал

Өнгөрсөн 30 жилийн харилцааны *нэгдүгээр үе шат буюу 1991-2001 онууд* бол өмнөх сөргөлдөөнт үеийн хүндрэлийг даван туулж, найрамдлын гэрээ байгуулах бэлтгэлийг хангасан үе юм. ЗХУ 1980-аад оны дунд үеэс БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгох чиглэлээр санаачилга гаргаж эхэлсэн. Энэ үес хоёр улсын харилцаанд тодорхой хүндрэлийг бий болгож байсан нэг зүйл нь БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр байрлаж байсан зөвлөлтийн цэргийн асуудал байлаа. Энэ асуудлыг хятадын талд зохих "буулт" хийх замаар шийдвэрлэснээр хамтын ажиллагаа эхлэх "үүд нээгдсэн" юм. 2000 он хүртэлх харилцаа ерөнхийдөө 1989 оны зарчимд суурилж, хоёр талын харилцаанд хил орчмын асуудлаа шат дараатай шийдэх, дайсагнасан байдлаа цуцлах, итгэлцлийг бий болгох, хэвийн горимд шилжүүлэх гэсэн үзэл санааг шингээсэн байлаа.

Хоёрдугаар үе шат буюу 2001-2012 он.

Энэ цаг үед хоёр талын харилцаа итгэлцэл сэргэж, цаашдаа тодорхой хүрээнд хамтарч ажиллах боломжтой гэдгийг харуулсан. ОХУ, БНХАУ-ын хооронд 2001 онд байгуулсан "ОХУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагаа, сайн хөршийн тухай гэрээ" нь нийт 25 зүйлтэй, 20 жилийн хугацаатай, хоёр улсын харилцааны шинэ хэлбэрийг баталгаажуулсан баримт бичиг болсон. Гэрээгээр талууд хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүлээн зөвшөөрч, түүнийг сахин хамгаалах, хоёр талын хамтын ажиллагааг бүх талаар гүнзгийрүүлэх, хилийн районд зэвсэглэл хорогдуулах тухай, харилцан итгэлцлийг бэхжүүлэх тухай, орос-хятадын улсын хилийн зүүн болон баруун хилийн хэсэгт демаркацийн тухай, ШХАБ-ын хүрээн дэх идэвхтэй хамтын ажиллагааны тухай, Хятадын Зүүн-Хойд бүс, Оросын Алс Дорнод, Дорнод Сибирийн хооронд хамтын ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг идэвхжүүлэх, түүнчлэн хоёр талын хамтын ажиллагааг НҮБ, Их-20 болон хамтын ажиллагааны бусад олон талт хэлбэрүүд болох ШХАБ, БРИКС, РИК г.м. эрэмбэлэн бүх талаар хөгжүүлэх[2] хэмээн заажээ.

2001 оны Гэрээний гол үзэл санаа нь уг баримт бичиг бол эвсэл, холбоотны гэрээ бус, гуравдагч этгээдийн эсрэг чиглэгдээгүй гэдэгт оршиж[3] байв. Хоёр тал Төв Азийн хөрш улсууд нь өөрсдийн гэсэн өвөрмөц түүх, соёлтой улсууд тул түүнийг хүндэтгэн үзэх, тэдгээрийн сонгосон хөгжлийн зам, бүрэн эрхийг бүрэн хэмжээнд хүндэтгэн үзэхээ илэрхийлсэн байдаг.

2 Проблемы Дальнего Востока № 4, 2011 г.

3 Источник: http://naukarus.com/dogovor-2001-g-kak-pravovaya-osnova-rossiys-ko-kitayskogo-strategicheskogo-partnerstva

2012 оноос эхэлсэн “Хятадын мөрөөдөл” үзэл баримтлал нь нэгд, хүчтэй баян улс, хоёрт, үндэсний сэргэн мандалт, гуравт, ард түмний аз жаргалд тус тус суурилсан болно. Үүнд хүрэх арга замын нэг бол Евразид эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх явдал гэжээ.

“ОХУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагаа, сайн хөршийн тухай гэрээ”-нд хийсэн дүгнэлт гэвэл:

- *Хилийн асуудлаа зонхилж шийдсэн ба тэндээс зохих цэрэг-техникээ татсан*
- *ОХУ нь Ази руу чиглэсэн бодлогоо идэвхжүүлсэн*
- *Дундад Азид ШХАБ-ын хүрээнд хоёр тал зохицож чадсан*
- *Хятадын хувьд Оросоос түүхий эдийн импортоо нэмэгдүүлэх сонирхлоо илэрхийлсэн*
- *ОХУ-ын хувьд түүхий эдийн зах зээлээ өргөтгөх сонирхлоо илэрхийлсэн*
- *Аль аль нь АНУ-ын ганцаар оройлох дэг журмын эсрэг хамсаатан эрэлхийлсэн*
- *Дотоод задралын үйл явц хоёуланд нь байгаа тул үүний эсрэг олон улсын дэмжлэг шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн*
- *Урьдын сөргөлдөгч байсан харилцаанд цэг тавьсан*
- *Хоёр орны харилцааны шинэ үеийн эхлэлийг тавьсан явдал болой.*

Гуравдугаар үе шат буюу 2013 оноос хойших үе.

Ингэж авч үзэх үндэслэл нь *нэгд*, АНУ-Хятадын харилцааны шинж буюу “Хятад мөрөөдөл”, *хоёрт*, АНУ, ЕХ-ны зүгээс ОХУ-д тавьсан хоригтой шууд хамааралтай. Дэлхийн хоёр дахь эдийн засаг болсон Хятад улс 2010 оноос гадаад бодлогодоо ихээхэн өөрчлөлт оруулсан. Хоёр улсын дээд удирдлагын шинэ хамтын ажиллагааны үе эхэлсэн. В.Путины бүрэн эрхийн 12 жилийн шинэ тоолол, Ши Жинпины хугацаагүй удирдлагын цаг тоолол энэ цаг үеэс эхэлсэн тул хоёр улсын харилцааны шинэ үе эхэлсэн хэмээн үзэх боломжтой.

Орос, Хятадын хамтын ажиллагааны тухай 2014 оны Шанхайн стратегийн хэлэлцээрт хоёр талын төмөр замын стратегийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, тариф, маркетинг, Хятад-ОХУ-Европ гэсэн транзит тээвэр, шингэрүүлсэн шатдаг хий нийлүүлэх асуудлуудыг зохицуулах, Алс Дорнодод хятадын хөрөнгө оруулалттай хэд хэдэн төслийг хэрэгжүүлэх зэрэг зүйл заалтууд тусгагдсан байгааг анхаарах ёстой. ОХУ-ын “Газпром” компаниас “2030 он хүртэлх ОХУ-ын байгалийн хийн салбарын хөгжлийн хөтөлбөр” нэртэй төслийг боловсруулсан. Энэ нь Хятадын зах зээлд голлон түшиглэсэн хөтөлбөр. ОХУ-ын “Газпром”, БНХАУ-ын “CNPC” хооронд 30 жилийн хугацаатай 400 тэрбум ам.долларын өртөг бүхий гэрээ байгуулсан нь дэлхийн хийн түүхэн дэх хамгийн том гэрээ. Нийлүүлэлтээ баруун, зүүн гэсэн чиглэлээр хангахаар төлөвлөсөн. Хятад нь оросын хийн хувьд импортын татварыг тэглэхэд бэлэн гэдгээ мэдэгдсэн бол Орос нь хийн орд газарт ашигт малтмал олборлоход тавих татвараа тэглэхэд тус тус бэлэн гэдгээ мэдэгдсэн. Хоёр тал гадаад бодлогын алхмуудыг уялдуулах талаар тохиролцов.

БНХАУ-ын гадаад бодлогын 2015 оны Цагаан номд тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлохдоо ирээдүйн дэлхийн дэг журам, олон улсад байр суурьа нэмэгдүүлэх, цэргийн салбарт тэргүүлэх байр суурь эзлэх, Хятадын нөлөөг нэмэгдүүлэх, эрэг орчмын газар нутагтаа төдийгүй, гадаад далайд аюулгүй байдлаа хангахад шилжих, бусад улс оронтой, нэн тэргүүнд ОХУ-тай цэргийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрхэмлэх явдал хэмээн заасан.

БНХАУ-ын гадаад бодлогын стратегийн үндэс нь энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчим билээ. Үүнд: бие биесийнхээ газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтлох, бие биенийхээ дотоод хэрэгт үл оролцох, тэгш харилцан ашигтай байх харилцааг эрхэмлэх, энх тайвнаар зэрэгцэн орших. 2015 онд Ши Жинпин ОХУ-д айлчлах үеэрээ “ЕАЭЗХ ба Эдийн засгийн Торгоны зам, бүсийн харилцан холбоог хангах ОХУ, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэл” гаргасан. Оросууд Торгоны зам төсөлд анхнаасаа “болгоомжтой” хандаж ирсэн бол энэхүү мэдэгдэл нь тэрхүү болгоомжлолд бага ч гэсэн тайлбар болсон юм. 2017 онд Хятадын дарга Ши Жинпин ОХУ-д айлчлахдаа хийсэн хоёр талын албан мэдэгдэлд ОХУ-Хятад-Монголын эдийн засгийн коридор байгуулах, Транссибирийн төмөр замаар Европ руу ачаа тээвэрлэх нөхцөлийг сайжруулахад харилцан арга хэмжээ авах зэргийг тусгасан.

2019 оны айлчлалын үеэр Ши Жинпин “хамгийн чухал нь Хятад, Оросын харилцааны стратегийн ач холбогдол бүхий асуудлуудаар бид нэгдмэл байр суурьтай байдаг төдийгүй хоёр улсын харилцааг урт хугацаанд гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд

чиглэсэн нийтлэг хүсэл сонирхол бидэнд бий” хэмээн мэдэгдсэн. Хоёр талын 2019 оны хамтарсан мэдэгдэлд: “хоёр орны харилцааг бүх талын түншлэл, стратегийн харилцаа, урт хугацааны хамтын ажиллагааг шинэ үе шатанд бүх талаар хөгжүүлэх тухай”, “орчин үеийн глобал стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагаа”-ны тухай тусгасан. АНУ-ын гадаад бодлогын үйл ажиллагааг буруутган, одоогийн оршин буй тогтолцоог эвдсэн алхам хэмээн тохиролцогч талууд үздэг ч уг мэдэгдэлдээ их гүрнүүдийн хамтын ажиллагаа чухал хэмээн АНУ-д хандсан байна.

2019 онд Орос-Хятадын хооронд байгуулсан 25 гэрээний ерөнхий агуулга нь:

1. ОХУ-ын ХАА-н бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлох хэлэлцээрүүд,
2. Хятадын хөрөнгө оруулалтыг ОХУ-д дэмжсэн хэлэлцээрүүд,
3. Талууд шинэ технологийн салбарыг түлхүү дэмжихээ илэрхийлсэн хэлэлцээрүүд гэсэн үндсэн 3 хэсэгт хуваан үзэж болно.

Тоймлож хэлэхэд, 1992 оны “Бээжингийн тунхаглал” нь хоёр орны төрийн тэргүүн нарын жил бүрийн уулзалтын үр дүн, цаашид хоёр улсын харилцаа хамтын ажиллагаа болон тухайн асуудлаарх “замын зураг нь” болж ирсэн. 2001 оны Гэрээ хүртэл хамтарсан мэдэгдлүүд нь хилийн бүсийн, хил хязгаарын талаарх ойлголцол, аюулгүй байдал, цэрэг-техникийн гэсэн чиглэлд түлхүү анхаарч зохицуулах чиглэлтэй явж иржээ. Харин 2001 оноос олон талт хамтын ажиллагааг талууд дэмжиж, тэр чиглэлд хамтран ажиллахыг тунхаглах болсон. 2008 оноос эдийн засгийн хамтын ажиллагааг талууд илүүд үзсэн бол 2012 оноос олон улсын дэг журмын талаар талууд хамтарсан мэдэгдэлдээ түлхүү анхаарч эхэлжээ. Тунхаглал нь хэдийгээр хоёр талын санаа зоригийн илэрхийлэл, байр суурь хэдий ч зайлшгүй хэрэгжүүлэх гэрээ хэлцэл биш тул зөвхөн ерөнхий чиг хандлагыг тандах боломжийг олгодог.

Өнөөгийн нөхцөлд ОХУ, БНХАУ нь дэлхийн зах зээл дээр өрсөлдөгчид бус, бие биенээ нөхөх үндэслэлтэй юм. Хэдийгээр улс төр, үзэл суртлын өөр өөр тогтолцоотой, өөр байр суурьтай ч, зөрчлийг тойрч гарах, зөвшилцөж чадах эрх ашигтай улсууд. Улс төрийн ижил буюу нэг системтэй байх үедээ байлдаж байсан улсууд өөр системд шилжсэн өнөө үед байлдах бол “энүүхэнд” хэмээн үзэж болно. Хоёр орны хооронд стратегийн нэгдмэл сонирхол бий болоогүй нөхцөлд тийм харилцаа явуулах систем тогтсон хэмээн үзэх нь үндэслэлгүй зүйл. Аль аль нь Өрнөдтэй сайн харилцааг бий болгох далд хүсэлтэй улсууд. Одоогоор хоёул Өрнөдтэй “төвөгтэй” байдалтай байгаа тул түр хоорондоо “найз” гэсэн дүгнэлт хийж буй судлаачид ч бий. Хоёр талын харилцааны гол зүтгүүрийг “улс төрийн ойртох үйл явц” гэж тодорхойлсон нь улам “барьцгүй” харилцаа хэмээн харагдуулж байна.

Оросын хувьд БНХАУ нь эрчим хүчний том зах зээл, оросын зэвсгийн экспортын үндсэн хэрэглэгчдийн нэг, мөн банк санхүү, хөрөнгө оруулалтын том түнш. Хятадууд техникийг, технологийн хамт цаашдаа өөртөө үйлдвэрлэх нөхцөлтэйгөөр худалдан авахыг гол болгодог нь хоёр хөршийг тодорхой зөрчилд хүргэдэг. Хятад нь эдийн засгийн хувьд хүчтэй харагдаж байгаа ч эмзэг байгаа. Учир нь Хятадын экспорт, импортын логистикийн стратегийн дэд бүтэц нь бүхэлдээ АНУ-ын хяналтад байгаа. Хятадын хувьд Орос нь Европын зах зээлд гарах гарц, мөн ЕАЭЗХ нь өөрөө “чамгүй” зах зээл.

> *1990-2020 оны хоёр талын харилцаа “дайсагналцлыг зогсоож, итгэлцлийг бий болгох үе буюу 1990-2000 он”, “Хэвийн харилцаа тогтоох, итгэлцлийг бэхжүүлэх үе буюу 2001-2013 он”, “Идэвхтэй харилцаа буюу стратегийн түншлэлийг хөгжүүлсэн үе буюу 2013 оноос хойших” гэсэн 3 үеийг туулж иржээ.*

Энэ цаг үед талууд бие биенээсээ өрсөж цөмийн зэвсэг хэрэглэхгүй гэдгээ тохирсон. Түүнчлэн өөрсдийн сонгосон улс төр эдийн засгийн тогтолцоонд хүндэтгэлтэй хандахаа ч илэрхийлсэн[4].

Орос, Хятад нь харилцан бие биенээсээ үл хамааран оршиж чадах, аль аль нь бие даан орших хэмжээний чадвартай улсууд учир харилцан хамтын ажиллагааг стратегийн түншлэлийн хэмжээнээс илүү гаргах, тухайлбал холбоотон болох хэмжээний сонирхол багатай[5]. Аль аль нь өөрийн гэсэн ашиг сонирхол, тэргүүлэх чиглэлтэй улсууд. Олон асуудлаар байр суурь одоохондоо ижил ч, ямартай ч сөргөлдөгчид бус ч, өрсөлдөгчид гэдэг нь бодитой зүйл болой.

4 http://naukarus.com/nadezhnaya-osnova-rossiysko-kitayskogo-strategicheskogo-partnerstva-druzhby-i-sorazvitiya

5 Печерица В. Ф. Э Чжун Гуаньси Дэ Синь Цзедуань Тунмэн Хайши Чжаньлюэ Хобань Гуаньси? // Элосы Сюэ. — 2015. — No 4. — С. 73. Чэн Чжицзе. Ван Чжуан Хобань Вайцзяо Цзичжи: Чжун Э Хэцзо Дэ Синь Туцзин //Элосы Яньцзю. -2015. - No 3. - С. 130-133.

Д.Баярхүү*
Судлаач-профессор

ЛАЛЫН ШАШНЫ ТҮРЛЭГ & СОЁЛЫН ҮЛ ОЙЛГОЛЦОЛ

Лалын ертөнц бужигнасаар, байлдсаар, бас ч үгүй хоёр том эвсэл болж хагарах гэж ч байгаа юм шиг. Иймд тэр сэдвээ дахин, гэхдээ өөр өнцгөөс хөндөж байна.

Турк, Пакистан, Малайз, Катар дөрөв шинэ альянс байгууллаа гэх мэдээ хэдэн сарын өмнөөс чих дэлссэн. Дэлхийн сошиал сайтуудад ганц нэг мэдээ тавигдсан. Лалын арабын ертөнцийг бага сага гадарладаг, тэнд нь алба хашсан, тэр ертөнцийн талаар ном бичсэн хүний хувьд би энд юу болчив хэмээн сонирхож, болж өгвөл дүн шинжилгээ хийчих санаатай сурвалжлаад үзлээ, баримт цуглууллаа. Тэр тухайд дараа өөр нэг өгүүлэлдээ бичнэ. Юу гэвэл Лалын ертөнцөд "засгийн эрх" солигдож хүчний төв Араб төвөөсөө өөр тийшээ шилжиж байна уу гэх хар буулаа. Арабчууд "арабын хавар"-т дайрагдаж өвөр хоорондоо түнжин тасарч, зарим улс нь эх толгойгүй хоорондоо дайтаж дайны хөлд сөхөрч (Сири, Ирак, Ливи, Йемен гэхчлэн) тэднийг захирдаг, залдаг, чиглүүлдэг, халамжилдаг Араб нэг ч улс байхгүй тохиолдолд Арабын нэг улсыг нь (Катар) урвуулаад Арабын биш гурван улс эвсэл сэдсэн нь ил болжээ.

Харин энэ удаа Ислам-Европын зөрчлийг хөндлөө. Өгүүллийн гарчгаа бодож бодож ингэж авлаа. Соёлоос үүдсэн мөргөлдөөн гэж буухаар байна. Эсрэг тэсрэг соёлууд хэн хэнээ яагаад, хэрхэн ялгаварлав гэж хардахаар бичлээ. Хэн нэгэнд нь шууд буруу өгөхгүй. Бүгд эх сурвалжтай бодит түүх. Лалын соёл, сэтгэлгээ, сэтгэхүй нь хүнийг хэн болгочихдог юм бэ гэдгээс бүх үйл лай эхтэй хэмээн үзсэнээ дор буулгаж байна.

"Ялгаварлагдсан" баатрууд маань бол лалын шашинтнууд– мусульманчууд. Тэдний сэтгэлийн угт нь омогшил байдаг. Төрөхөөсөө л омогшилтой ертөнцөд ирдэг. Харин буцдаггүй. Нас барлаа, үхлээ, алууллаа гээд байгаа нь Аллах руугаа очиж буй хэрэг болохоос ертөнцөөс явчихаж байгаа хэрэг биш. Жибрил тэднийг тосч аваад Аллахад мэдүүлэхээр хүлээлгийн өрөөнд суулгаж байна. Дэлхий төгсгөл болсон өдөр Аллахын хаалгыг нээж өгнө. Лалын сургааль номд нь тэгж бичээтэй буй.

Тийм ээ, бидэнд харагдсан жишээ. Афганистанд сураггүй алга болсон зөвлөлтийн дайчдаас мэр сэр олдсоор байна. Тэднийг эх оронд нь аваачиж эх эцэг, төрөл садантай нь золгуулах бүх ажил замхарсан. Тэд эргээд европжих нь бүү хэл, эх эцэг төрөл саднаа жигшээд Афган, Пакистан руугаа зуттана. Лалын шашны соёлын татан агуулах аугаа их увидас гэж үүнийг л хэлнэ. Нийгэмшүүлэх байтугай хүншүүлж чадалгүйгээр олон орос, украин залуусаа буцаагаад алджээ. Лалын омогшлыг нь Орос, Украин, Белоруссын төр давж чадсангүй ээ.

Тэд яагаад омогшилтой болчихдог юм бэ? Яагаад гэвэл хэзээ ч ганцаар байдаггүй. Аллах өдөр шөнөгүй сэтгэлийн мухарт нь уяатай. Зөнч Мухаммед өдөр шөнөгүй зөвлөж, ярилцаж, хазайвал түшиж, хамтдаа хорвоог туулж байна. Мухаммедийг ертөнцөд авчирсан Жибрил (Аллахын зууч) сайн муу үйлийг нь нягтлах хоёр хоёр сахиусан тэнгэрийг мусульман хүнд дагалдуулдаг ба тэр дөрөвтэйгөө цаад мусульман нөхөр 5-уулаа хорвоог туулж явна. Өөрөөр хэлбэл нэг мусульман хүмүүн 5-уулаа гэсэн үг. Ийм сүрлэг олуулаа, сэтгэлдээ тээх, ярилцах, сэтгэлээ хуваалцах аугаа их бурхантай хүн учраас мусульман хүн хаа явсан газраа омог бардам, олуулаа учраас маш бүлэрхүү, далдын их хүчтэй. Бусад шашинтанд дээрэлхүү, цэрвүү ханддаг нь ийм омогшлынх нь үр дүн. Орос, украин олзны залуус төрүүлсэн аав ээжээ нулимаад афганы нүцгэн уулын агуй руу тэмүүлэх нь тэр омогшлынх нь татан дагуулах увидас гэлтэй.

Ганц жишээ. Египетийн Ардын Хурлын чуулганы хуралдаан дээр болсон явдал. АНУ жил бүр 1.3 тэрбум ам.долларын тусламж өгдөг. Хүний эрх, шашны цөөнхийн эрх (христианчуудыг ихэд хэлмэгдүүлэх болсон) зөрчвөл тусламжаа зогсооно хэмээн Вашингтоноос сануулга өгөхөд "Лалын ахан дүүс"-ийн номлогч Мохаммед Хассан гэдэг хүн "АНУ бус Аллах Египетэд мөнгөөр тусалсаар ирсэн" гэж сүртэй зарламагц ард нийтээрээ

---

* Дашдоржийн Баярхүү нь Монгол Улсаас Арабын, Лалын орнуудад Элчин сайдаар ажиллаж байсан бөгөөд энд бичсэн нь манай Дипломат албаны байр суурийг тусгаагүй, зөвхөн судлаач эрдэмтний хувийн байр суурь болохыг анхаарна уу. Түүний бичсэн нь бодит баримт үйл явдалд хийсэн дүн шинжилгээ болно –"Бодлогын мэдээ" сэтгүүлийн редакц

америкийн биш, Аллахын мөнгөн тусламжийн тухай шаагилдах болсон.

Яг ийм итгэл үнэмшилтэй түм бум, сая сая дүрвэгч цагаач Европыг сүүлийн 10-аад жил нооллоо доо. Энэ манай соёл биш гэсэн нь уугуул христиан европчуудын цөхрөлийн үгсийг (бараг эцсийнх) яалтай билээ. Европчууд мэдээж сэтгэл дундуур, бүр түгшүүртэй. Трамп гэж бас нэг сэтгэл дундуур нөхөр далайн чанадаас тэднийг элдвээр хатгасан, хатгасаар ч байна. Умард Африк, Ойрхи Дорнодоос урсах дүрвэгсэд, хууль бус цагаачдын урсгалаас болоод Европ "өөрийн соёлоо алдаж буй" тухай тэрээр британийн хэвлэлд ярилцлага өгч байв. "Бид соёлоо гээгээгүй" гэж ирээд л тэр үеийн Британийн Ерөнхий сайд хатагтай Тереза Мэй хатагтай мэтгэлцэж байсан даа. Тэгэхлээр нь Трамп мэтгэлцээнд ялж байнаа. "Европ ийм их миграцтай байгаа нь гутамшиг" гэж ирээд л авч өгөв. Та нарын энэ их цагаачлал чинь Европын бүтцийг өөрчилчихлөө. Одоо л шийдэмгий ажиллахгүй бол өмнөх шигээ Та нар байна гэж гонж, бид нааштай өөрчлөлтийг үзэхгүй"–Трампын анхааруулга.

Трамп Германыг ч халаглан ярьж байна. Сириэс ганц жилд 722 мянган дүрвэгч хүлээн авах тухай хатагтай Ангела Меркелийн шийдвэрийг "Германд маш ноцтой цохилт өглөө. Европын бусад хэсэгт ч ноцтой хохирол учруулаа. Улс төрийн хувьд тэгж ярьж болохгүй байх. Тэгэхдээ би яадаг юм чангахан мэдэгдчихье. Танай соёл чинь өөрчлөгдөөд байна, үүндээ анхаарлаа хандуулаач. Та нар маш их юмаа өөрчилж байна. Та нарын аюулгүй байдлын бүтэц чинь өөрчлөгдлөө шүү дээ" – Трамп ингэж анхааруулжээ.

Европын Холбооноос АНУ-д суугаа Элчин сайд Дэвид О'Салливан хүлээн зөвшөөрч байнаа. Бидэнд цагаачлалын маш том асуудал бий. Дөнгөж сая цагаачлан ирсэн байтугай 20, бүр 30 жилийн өмнө ирсэнүүдийг нь Европтоо дасгаж чадаагүй байна. Энэ л том аюул. Бид үүнийг гүнээ ухамсарч байна. Бид тэдэнд хамгийн сайн сайхнаар ханддаг. Тэглээ гээд тэд Европын соёл ба иргэншилд ямар нэг хэмжээгээр заналхийлсээр байна. Гэхдээ цагаачлал Европын соёлыг өөрчиллөө гэх нь алдаатай үзэл шүү. Европ тив лав ойрын үед мусульманчуудын тив болж хувирахгүй хэмээн "Washington Examiner"-д тэрээр ярьжээ.

Трампын сануулгад холын жишээ, элдэв тайлбар хэрэггүй. Жишээ хайя. Парисыг байнга л цэвэрлэсээр улиг болжээ. Дүрвэгсэд суусан газраа «жүнгли» болгоод тавьчихсан байхад нь цэвэрлээд л, цэвэрлээд л, барагдах юм биш. Их Британи руу гарах гэсэн түг түмэн дүрвэгч Францын Кале хэмээх боомт хотыг нохойн хороо болгоод тавьчихсан дүрс ТВ-ээр гарч байв. Герман, Норвег, Швед, Финланд, Австри хаа л бол хаа мусульман дүрвэгч цагаачдаас дөлнө, зэвүүцнэ, орон гэрээ орхиод өөрсдөө дүрвэнэ. Зэрэгцэн амьдрах нэн аюултай гэнээ. Нөгөө омогшил, омогшлоос үүдсэн лалын соёлоос нь залхаж, зайлж байгаа нь тэр л дээ. Унгар, Польш, Чех, Словак Брюссельтэйгээ квотын асуудлаар илд зөрүүлэхийн наагуур хэдэн жилийг үзэж байна. «Аллах Акбар!» хэмээх лалын сүмийн унзад дуугаар сэрж, өдөртөө 5 удаа тэгж мэгзэмдэх, танихгүй зүс мэдэхгүй, нүүрээ битүүлсэн, эсвэл сахал үүсэндээ баригдсан, харь хэлтэй мянга түмэн хүн төрөлх хотоор нь хөлхөлдөхийг тэд тэвчихгүй.

Ойрхи Дорнод, Африкаас ирсэн дүрвэгсэд өөрсдөө таагүй, мэдээж баярлахгүй, гэхдээ буц гэвэл буцахгүй, Европт жаргалтай байгаа учраас. Гэхдээ Европын соёл, түүх дурсгал, хүн ард, бүтээсэн босгосныг нь нэг нүдээрээ ч үзэхгүй. Учир нь тэдгээрийг Аллах бүтээгээгүй учраас. Аллахын тааллаас гадуур ёс суртахуунгүй, моральгүй. Материаллаг, оюуны хувьд бузартсан нийгэм Европынх гэсэн итгэл үнэмшил ухаан суухаасаа тархиндаа программчилчихсан учраас лалынхныг буруутгах бас аргагүй. Тиймдээ ч Европын хотуудад хогон овоо босгоод, гудамж зээлийг нь балиартуулаад, хүн ардыг нь нулимаад сууж байхаас аргагүй. Өөрсдөөсөө "долоон дор хүмүүс"-т тэгж хандахаас аргагүй.

Паранжа (гивлүүр) зүүлгэхгүй гэж европчууд мөн ч их тэмцжээ. Хууль гаргаж үзлээ. Бүтэлтэй юм болсонгүй. Мусульманчууд нь хариу шүүхдээд байх нь тэр. Хүний эрх, шашин шүтэх эрх зөрчлөө гэнгүүт шүүх төрийнхөө эсрэг шийдвэр гаргана. Бүр аргаа бараад Европын хүний эрхийн дээд шүүхэд төр засаг нь хандаад 2014 онд нэг удаа ялсан ухаантай. Францад гивлүүртэй гудамжинд явбал 150 еврогийн торгууль тавьж байгаа гэсэн ч яг хэрэгжиж чадаж байна уу?

Австрид хэтрүүлээд хаяжээ. Гивлүүрээс гадна урт нөмрөг, толгойн алчуур бүгдийг нь 150 еврогийн торгуультай болгожээ. Хууль батлах нь ч дүүрчээ. Туркийн хэт үндсэрхэг "Саарал чоно" байгууллагын төлөөлөл болсон 7 мечеть Австрид хаагдсан, учир нь хилийн чанадаас санхүүжилт авдаг гэж буруутгаад имамуудыг нь (хамба лам гэсэн үг) хөөж гаргажээ. Тэд нь туркийн үндсэрхэг үзэлтнүүдтэй холбоотой. Мөн "Арабын шашны нийгэмлэг" гэх бүлгийг тарааж,

тэдний мэдлийн 6 сүмийг хаажээ. Улс төрийн ислам гэгчийг Австрийн нийгэмд байлгахгүй гэжээ. Эдүгээ тус улсын тусгай албад 260 имамын 60-ынх нь судалгааг хийж хар дэвтэр нээжээ. Тэд нь Туркийн эрх баригчдын гар хөл болох ATIB гэгч лалын бүлгийн гишүүд, тэр 60-ын 11-ийг албадан гаргажээ. Австрийн тэр үеийн Канцлер Себастьян Курц анхааруулж байсан үгс: Параллель нийгэм, улс төрийн ислам, радикал урсгалд манай эх оронд орон зай байхгүй!

Австрийн нийгэмд интеграцад ор хэмээсэн хатуу шаардсан хууль баталжээ. Энэ бол тийм ч айхтар тулгалт биш л дээ. Лалын үнэт зүйлээ гэртээ хадгал, гэртээ мөргө, гэртээ Аллахтайгаа харьц л гэсэн үг. Лалын юм болгоныг Европын юм болгоны дээр гаргаж тавьж, европчуудыг мал шиг бүү үз, эсвэл исламыг шүтээгүйнх нь төлөө терроризм бүү хий, Зөнч Мухаммедын гэгээрч асан VII зууны дүрмээр бус, даяаршил, мэдээллийн эриний XXI зууны наад захын хэмжүүр шалгуурт тэнцээч ээ л гэсэн үг л дээ. Тэр дундаа шашнаа дэлгэрүүлэх, тулгахаар гаднаас санхүүжилт бүү ав аа л гэсэн үг юм санж.

Мусульман айлтай хааяа нийлсэн австри айл (ерөөсөө европ гэр бүл) айван тайван аж төрөх аргагүй, айдас хүйдэстэй, цаадуул нь байнга хялайна, илүү дутуу юмыг нь шомбодно, гуйлга гуйна, шашны мэгзэм дуугаа хэргээр чанга орилуулна, бохир заваан аж төрнө, хүн байнга холхино, шашны нууц бүлгэм аятай ажиллана, байр саваа тийм юманд ашиглана, юу санаж сэдэж яваа нь сэжигтэй гээд европын нэг сонины сайтад бичсэн байна лээ.

Данид парламент нь олонхоороо баяр ёслолын байдалтайгаар гивлүүрийн эсрэг хууль баталж байх юм. Эхний удаа зөрчвөл 134 еврогийн торгуультай. Дөрвөн удаа зөрчвөл, түүнээс олон зөрчвөл нэг тэг нэмээд 1340 еврогоор торгоно. Шоронд хорих тухай заалт тэр хуульд туссаныг хэлэлцсээр байгаад хойшлуулсан. “Гивлүүр нөмрөг бол Данийн соёлын нэг хэсэг биш гэдгийг манай парламент тов тодорхой ойлгууллаа”, “Мэдэжэрх чөлөө гэж бий. Бид хамгаалах ёстой. Харин толгойн алчуураар далимдуулан үзэл суртлаа тулгаж, бусад хүн ардын эрх чөлөөг хязгаарлахыг бид зөвшөөрөхгүй” – хэмээн иммиграцын асуудал эрхэлсэн төлөөлөгч Мартин Хенриксен ярьжээ. Гэртээ тэр алчуур гивлүүрээ зүүгээд мөргөлөө үйлдэж байвал барав хэмээн Данийн Хууль зүйн сайд Сёрен Полсон бараг тавлажээ.

Их Британийн Гадаад хэргийн сайд асан, одоо Ерөнхий сайд байгаа Борис Жонсон гэж засрашгүй исламофобист нөхөр байна. Христиан британичууд баяр хүргэж дэмжиж ялуулсан. Харин лалын идэвхтнүүд түүнийг Хүний эрхийн комисст өгч ял нэхэж хэрүүл дэгдээжээ. Нөмрөг нөмөрсөн мусульман бүсгүйчүүдийг шуудангийн хайрцагтай зүйрлээд бөөн хэрүүл дэгдээж шуугиулсан. Олон нийтийн газар нөмрөг намилзуулан явахыг шал тэнэг явдал хэмээн нэрлээд, нөмрөгтэй мусульман бүсгүйг “Яг банк дээрэмдэх гэж байгаа юм шиг” хэмээн зүйрлээд удахгүй амнаасаа болж (Үгүй ээ, миний энэ ам уу!) хэрэгт унахаар болоод авсан. Одоо энэ коронавирусын үед хэрэг нь намжсан. Харин корона тусч эмчилгээ хийлгэснийг нь Британийн мусульманчууд ёстой тавлан харж суусан байх.

Европчууд хэчнээн чардайгаад хяналтаа алдсаны нэг нотолгоо нь Швед улс болчихоод байна. Араб хэл тус улсын албан ёсны хоёрдахь хэл болж хуульчлагдахын наагуур байна. Фин хэлийг албан ёсоор швед хэлний дараа оруулж тооцож ирсэн нь цуцлагдахын даваан дээр байна. Үндсэн хуулиасаа хасахаас аргагүй боллоо. Дүрвэгсэд цагаачид тасралтгүй цувж байгаагаас араб хэл яалт ч үгүй түгээмэлжлээ. Тэр хэлээр тэр жижиг улсад 200 мянга гаран хүн төрөлх хэлээ хэмээн ярьж бичиж байна. Айван тайван байсан Мальмё гэдэг жижиг хот дүрвэгсдийн албан бус нийслэл нь болжээ. Хүн амын 40 гаран хувь нь араб, мусульман мигрантууд. Уужим сэтгэлт шведүүд тэр хотод гэрээсээ гарч чаддаггүй, гудамжинд ганц нэгээрээ яваа швед охид бүсгүйчүүл бол гэртээ үүрд хадагдахаас өөр аргагүй. Швед ажилчны тохилог намуухан хороолол эдүгээ харь хэлтнүүдийн шуугиант хот, араб маягийн хоол зуушны газрууд ярайгаад л. Үнэр танар ч болохоо байсан гэлцэнэ. Хотын уугуул иргэд нь хоол хүнс, эм тан, дулаан хувцсаа нөөцлөөд гэртээ бүгцгээжээ.

Гивлүүртэй хийх тэмцэл Европоос халиад Умард Америк руу салбарлалаа. Квебек 2018 оноос нүүрээ бүтээж нуусан ямарваа хувцас хунарыг хориглосон хууль үйлчилж байна. Яг тийм хувцас гэж заагаагүй ч лалын өмсгөл гэдэг нь ойлгогдоод байна. Гивлүүртэй мусульман бүсгүй хэрэв цагдаа, төрийн албан хаагч, багш, эмч, нийгмийн ажилтан байдаг бол ажлаасаа халагдах, эсвэл оройн цагаар гэртээ тэрийгээ зүүж өөртөө таашаал авч байх боллоо. Бараг л ажлаа өгөөд яв гэсэн битүү сануулга тэр хуульд байна. Квебекийн Ерөнхий сайд Филипп Куйяр бахдалтай ярьж байна: Нүүрээ ил гаргаад яв, тэгэхээс ч өөрөөр байх арга алга. Олон шалтгаантай шүү!

Л.Удвал
Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

ОХУ, ХБНГУ ХОЁР "УМАРДЫН УРСГАЛ -2"-ЫГ УДАХГҮЙ ДУУСГАХ УУ?

ОХУ-аас ХБНГУ-г хүртэл Балтийн тэнгисийн усан доогуур тавигдаж буй "Умардын урсгал-2" хэмээх байгалийн хийн хоолойг барьж дуусгах ажил улс төрийн гэж үзэж болох тодорхой зарим шалтгааны улмаас тасалдаад байгаа нь олны анхаарлыг татах болов. Уг бүтээн байгуулалт нь төгсгөлийн шатандаа яваа буюу ердөө 160 орчим километр хоолой угсрах ажил л үлдээд байгаа билээ.

Европын орнуудын эрчим хүчний хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй гэгдэж буй энэхүү төслийн бүтээн байгуулалтыг 2011 онд тэр үед ОХУ-ын ерөнхийлөгч байсан Дмитрий Медведьев, Холбооны канцлер хатагтай Анжела Меркель нар албан ёсоор нээсэн юм. 1988-2005 онд ХБНГУ-ын засгийн газрыг тэргүүлж байсан германы нэрт улс төрч Герхард Шрөдер Холбооны канцлерын албаа өгснөөсөө хойш хоёрхон сарын дараа орос-германы хамтын ажиллагааны билэгдэл болох учиртай энэхүү "Умардын урсгал-2" төслийн захиргааны зөвлөлийн даргаар ажиллах болж уг албыг өнөө хүртэл хашиж байгаа нь ОХУ болон ХБНГУ уг төсөлд үлэмж ач холбогдол өгч ирсний илрэл мөн. Энэхүү төслийг хэрэгжүүлж эхлэхдээ хоёр тал "Умардын урсгал-2" бол цэвэр эдийн засаг, худалдааны шинжтэй бөгөөд улс төрийн зорилго, агуулгатай төсөл биш хэмээн удаа дараа мэдэгдэж, уг төслийг эсэргүүцэгчид түүнийг улстөржүүлэн ойлгох, мушгин гуйвуулж саад тээг учруулахаас болгоомжилж ирсэн байдаг юм.

Анхны төлөвлөгөө ёсоор бол 2020 оны нэгдүгээр сард ашиглалтанд орох байсан энэхүү төсөл хэрэгжсэнээр ОХУ энэ сувгаар жилдээ 55 тэрбум кубметр байгалийн хий нийлүүлж 26 сая айл өрхийг одоогийнхоос нь 13 орчим хувь хямдаар хангах бөгөөд Европын холбооны орнуудад 57,5 мянга орчим ажлын байр бий болгох учиртай. Эдүгээг хүртэл уг төсөл ОХУ-ын Газпром компаниас гадна Герман, Дани, Финланд, Швед болон европын бусад орны нийтдээ 120 орчим их, бага пүүс компанийн оролцоотойгоор хэрэгжиж, нийт төлөвлөсөн 2460 км хос хийн хоолойн 2300 километрийг усан доогуур тавьсанаар 2019 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 93,5 хувийн гүйцэтгэлтэй явж байжээ.

Гэвч энэхүү нүсэр том бүтээн байгуулалтын ажил Кремлийн бодлогыг эсэргүүцэгчдийн гол төлөөлөгч Алексей Навальныйг "Новичок" хэмээх үхлийн бодисоор хордуулсан гэх дуулиан шуугианы дараа ийнхүү зогсонги байдалд ороод байна.

Аль аль талдаа ашигтай гэж үзэж болохуйц энэхүү төслийг АНУ, Польш, Украин зэрэг зарим улс анхнаас нь шүүмжилж ОХУ-ын геополитикийн нөлөөгөө тэлэх бодлого хэмээн эсэргүүцэж ирсэн юм. АНУ-ын ашиг сонирхолд нийцэхгүй бөгөөд Европын Холбоог ОХУ-ын эрчим хүчний хараат болгох аюултай гэх буюу оросууд байгалийн хийгээ Украинаар дамжуулахаа болих замаар түүнийг эдийн засгийн хувьд хавчин сульдаах бодлого явуулахыг санаархаж байна хэмээн хурцаар шүүмжилсээр байна. АНУ оросуудын эсрэг тавьсан хоригийн бодлогынхоо дагуу ОХУ-тай "Умардын урсгал-2" төслийн хүрээнд хамтран ажиллаж буй компаниудыг энэхүү хоригтоо хамааруулан авч үзэж байгаа учраас хийн хоолой угсрах ажил гүйцэтгэж байсан Швейцарь зэрэг зарим орны хөлөг онгоцууд үйл

ажиллагаагаа зогсоосон нь уг төслийн ажилд багагүй бэрхшээл учруулсан юм.

Ийм нөхцөлд ОХУ-ын зүгээс хийн хоолой угсрах ажлыг өөрийн хүчээр хийж дуусгахаа мэдэгдсэн бөгөөд оросын тусгай зориулалтын "Академич Черский" хэмээх хөлөг онгоц германы Мукран боомтод бэлхэнээ хүрэлцэн ирээд байгаа аж. Харин германы БАСФ, ЕОН зэрэг томоохон пүүс компаниуд АНУ-ын хориг, дарамт шахалтыг үл хайхран энэхүү төсөлд хамтран ажиллахаа цаашид үргэлжлүүлбэл ХБНГУ-ын Засгийн газрын зүгээс бодитой дэмжлэг, хамгаалалт авч чадах уу гэсэн асуудал тавигдсан хэвээр юм. Тийм хамгаалалтгүйгээр цааш үргэлжлүүлэн ажиллавал цаашид эдгээр компанийн АНУ-тай хамтран ажиллах боломж огцом хумигдаж, улмаар тасалдан үлэмж хэмжээний хохирол амсах, өр төлбөрт унах магадлал байгаа ажээ.

ХБНГУ-ын засгийн газар энэхүү төслийг улстөржүүлэхгүй, эдийн засгийн төсөл гэдэг утгаар нь үргэлжлүүлэн дуусгах сонирхолтой байгаа хэдий ч А.Навальныйн эрүүл мэндийн байдлыг тойрсон асуудлаас болоод ОХУ-ын эсрэг хоригоо чангатгах АНУ-ын бодлого болон Европын Холбооны удирдлагын зүгээс баримталж болзошгүй болоод байгаа хатуу байр сууринаас шалтгаалан өөрийн байр суурийг эргэн харахаас өөр аргагүйдэж магадгүй болоод байна.

Холбооны канцлер Анжела Меркель "Умардын урсгал-2"-ыг А.Навальныйн эрүүл мэндийн асуудлаас тусад нь авч үзэх ёстой хэмээн саяхан болтол мэдэгдэж байсан боловч ЕХ-ны хүрээнд Францын ерөнхийлөгч Э.Макрон сайхь А.Навальныйн асуудлаас үүдэн байр сууриа өөрчлөхөд хүрсэн, Германы дотоодод Анжела Меркелийн эл асуудлаарх байр суурийг дэмжигсэд эвслийн засгийн газрын гишүүдийн дотор болон ерөөс германы улс төрчдийн хүрээнд ч цөөрсөөр байгаа зэрэг нь түүний бодлогод аргагүй нөлөөлж буй бололтой. Байдал цаашид энэ янзаараа үргэлжилбэл Анжела Меркель европын тэргүүлэх улстөрчийн хувьд дотооддоо байр сууриа аль болох бага хохироох, Европын Холбоог эдүгээ даргалж байгаа орны засгийн газрын тэргүүний хувьд Европын Холбоогоор нөмөр хийн нэр бүтэн гарах арга хайхад хүрч мэдэхээр байна.

Чингэхэд хүрвээс ХБНГУ-ын Засгийн газар "Умардын урсгал-2"-ын талаар баримтлан хэрэгжүүлж ирсэн байр сууриа эргэн харж ЕХ-ны орнуудын байгалийн хийн нэгдсэн зах зээлийн талаарх чиг шугамыг баримтлахад хүрэхээс гадна ЕХ ны гишүүн орнуудтайгаа дээрх асуудлаар консенсусын зарчим баримтлахын оронд ихэнхдээ "ганцаарчилсан тоглолт" хийж, заримтай нь бүр эсрэг тэсрэг байр суурьтай явж ирснээ хянан залруулахад хүрч мэдэхээс гадна АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трампад "энэхүү төслийг бүрэн зогсоох боломж ч бий" хэмээн анхааруулж байсан америкийн зарим дипломатын мэдэгдэл хэрэгжихэд хүрч мэдэх эгзэгтэй цаг үе бас тулж ирээд байгаа юм. Эдүгээ АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль ойртох тусам Дональд Трамп "Умардын урсгал-2"-ын талаар германчуудад болон ялангуяа оросуудад ямар "гэнэтийн бэлэг" барих нь тодорхойгүй байна.

Үүний зэрэгцээгээр мөнөөх "Новичок" хэмээх хорт бодисыг Кремлийнхэнд үл таалагдах зарим хүмүүсийн эсрэг хэрэглэж байсан гэх өмнөх тохиолдлууд ч сөхөгдөж магадгүй байна. "Новичок"-ийг Навальныйн эсрэг хэрэглэсэн тухайд ОХУ-ын тал даруй мөрдөн шалгах ажиллагаа явуулж үр дүнг нь нийтэд мэдээлэх ёстой гэж германы тал үзэж байгаа ч одоогоор тодорхой болсон зүйл бага, харин ч ээдрээтэй олон асуудал байгаа гэж зарим шинжээчид үзэж байна. Тухайлбал, Навальныйг хордуулсан нь баттай гэж үзвэл Берлиний "Шарите" эмнэлэгт ухаангүй очсон түүний эрүүл мэндийн байдал хурдан дээрдэж , улмаар удахгүй эх орондоо очиж Кремлийн эсрэг тэмцлээ үргэлжлүүлнэ хэмээн мэдэгдэж байгаа нь зарим шинжээчдийн эргэлзээг төрүүлж байгаа ажээ. Нөгөөтэйгүүр "Новичок" нь тухайн хүний хувцас хунар, эд хэрэглэлээр нь дамжин хордуулахуйц хүчтэй химийн хорт бодис атал германчууд иймэрхүү хордолтоос хамгаалах онцгой горим баримталсан эсэхэд зарим нь эргэлзэж Навальныйн өмсч байсан хувцас хунарыг оросуудаас авч шинжлэх хэрэгтэй гэж үзэх явдал ч байгаа бололтой.

"Умардын урсгал-2" төсөл ийнхүү саатаж, энэ оны эцэс, ирэх оны нэгдүгээр улиралд хэрэгжүүлэн дуусгах боломжтой хэмээн саяхан мэдэгдэж байсан ОХУ-ын удирдагчдын найдвар суларсаар байна. ХБНГУ-ын Христосын Ардчилсан Холбоо намын даргын сонгуульд нэрээ дэвшүүлэн улмаар Холбооны канцлер А.Меркелийн залгамж

халааг авахын төлөө хүчтэй өрсөлдөгчдийн нэг-германы нэртэй улстөрч Ф.Мерц уг төслийг хэрэгжүүлж дуусгах ажлыг хойшлуулан 2 жилээр царцаах саналыг хүртэл тавьсан нь олны анхаарлыг татаад байгаа юм. Хэрэв тэгвэл германчууд АНУ-ын шахалтад бууж өгөн эрчим хүчний бодлогын хувьд хэрэг дээрээ бие даасан байдлаа алдахтай адил болох тул ийм шийдэл байж таарахгүй, ХБНГУ "Умардын урсгал-2 төслийг зогсоолгүй үргэлжлүүлэн дуусгах ёстой хэмээн мэдэгдсээр байгаа Герхард Шредерийн шаардлага талаар болж мэдэхээр байна.

Ийнхүү орос-германы хамтын ажиллагааны бодит билэгдэл болно гэгдэж байсан "Умардын урсгал-2" төсөл их гүрнүүдийн улс төр, эдийн засгийн сөргөлдөөн тэмцлийн золиос болоход ойрхон болоод байна.



ҮЙЛ ЯВДЛЫН ХЭЛХЭЭС

2020 ОН

06.24 Монгол Улсын Их хурлын ээлжит сонгууль болж МАН үнэмлэхүй ялалт байгуулав.

06.30 УИХ-ын анхны чуулган хуралдаж Г.Занданшатарыг даргаараа улируулан сонгов.

07.02 У.Хүрэлсүхийг Монгол Улсын Ерөнхий сайдаар дахин томилов.

07.07-8 МУ-ын шинэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг батлав. Үүнд:

Ерөнхий сайд	Ухнаагийн Хүрэлсүх
Шадар Сайд	Янгугийн Содбаатар
Хэрэг эрхлэх газрын дарга	Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ
Гадаад харилцааны яам	Нямцэрэнгийн Энхтайван
Сангийн яам	Чимэдийн Хүрэлбаатар
Хууль зүй, дотоод хэргийн яам	Хишгээгийн Нямбаатар
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Даваажанцангийн Сарангэрэл
Батлан хамгаалах яам	Гүрсэдийн Сайханбаяр
Боловсрол, шинжлэх ухааны яам	Лхагвын Цэдэвсүрэн
Барилга, хот байгуулалтын яам	Бэгзжавын Мөнхбаатар
Зам тээврийн хөгжлийн яам	Лувсангийн Халтар
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Аюушийн Ариунзаяа
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Загджавын Мэндсайхан
Эрүүл мэндийн яам	Тогтмолын Мөнхсайхан
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Гэлэнгийн Ёндон
Эрчим хүчний яам	Нансалын Тавинбэх
Соёлын яам	Сампилдондовын Чулуун

09.15-16 БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Тэрбээр ГХ-ны сайд Н.Энхтайвантай хэлэлцээ хийж, ерөнхийлөгч Х.Баттулга, ерөнхий сайд У.Хүрэлсүх нарт бараалхав.

09.20-22 Гадаад харилцааны сайд Н.Энхтайван ОХУ-д айлчлав. Гадаад хэргийн сайд С.В.Лавровтай хэлэлцээ хийж, 2019 оны 9 дүгээр сард хоёр төрийн тэргүүн нарын гарын үсэг зурсан "Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын Гэрээ"-ний батламж жуух бичгийг солилцов.

09.29 Монгол Улс "Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт" нэгдэн оров.

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД ТОВЧ НАМТАР

Н.Энхтайван
Гадаад харилцааны сайд

1970 онд төрсөн. Төрийн албанд 23 жил ажилласан. "Тэргүүн Шадар" дипломат цолтой.

Боловсрол	1989-1993 он	Бээжин хотын Худалдаа, үйлдвэрийн их сургууль, бакалавр
	1997-1998 он	Шинэ Зеланд Улсын Велингтоны Виктория их сургууль
	1998-1999 он	Монгол Улсын их сургууль, Эдийн засгийн магистр
	2004-2006 он	АНУ-ын Стрэйерийн их сургууль, бизнесийн удирдлагын магистр
Ажлын туршлага	1994-1999 он	Худалдаа, үйлдвэрийн яам, Гадаад харилцааны яаманд ажилтан
	1999-2003 он	Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-нд ажилтан
	2003-2004 он	Газрын тосны хэрэг эрхлэх газрын дэд дарга
	2006-2008 он	Төрийн өмчийн хорооны Тамгын газрын дарга
	2008-2011 он	Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-нд зөвлөх
	2011-2012 он	ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал
	2015 он	Монгол Улсын Шадар сайдын зөвлөх
	2016-2020	УИХ дахь МАН-ын бүлгийн ажлын албаны дарга
Гадаад хэл	Хятад, Англи.	